

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨД АНХААРАХ АСУУДАЛ

Д.Оюунбадам

Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт удааширч байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалттай зарим төслийн хэрэгжилт удааширч он дамжин, улмаар дуусгалгүй орхигдуулснаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашиггүй болгож байна. Улсын төсвөөс санхүүжиж өнөөг хүртэл дуусаагүй орхигдсон барилгуудад Үндэсний аудитын газар 2018 онд аудит хийж, он дамжсан төслүүдийг дуусгах чиглэлд Засгийн газраас авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж гаргасан боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.¹ Хөрөнгө оруулалтын олон төсөл он дамжин үргэлжилж байгаа нь Засгийн газраас УИХ-д өргөн бариад буй Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төслөөс харагдаж байна.² Тухайлбал, 2010-2016 онд эхэлсэн нийт 254.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий

24 барилга, байгууламжийн ажил дуусаагүй, удааширсан байдалтай байна (хавсралт 1-ийг харна уу). Эдгээр төсөлд 2021 оны төсвөөс 36.8 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөжээ. Зарим жишээ дурдвал, 2010 онд эхэлсэн нийт 68.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий дүүргүүдийн спорт цогцолборын 5 төсөл байгаагийн 4 нь Улаанбаатарт, 1 нь Дархан-Уул аймагт баригдахаар төлөвлөгджээ. 2011 онд эхэлсэн нийт 55.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөлд Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар; Барилга, байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лаборатори (Сонгинохайрхан дүүрэгт); Дорноговь аймгийн Сайншанд суманд байршилтай төрөх эмнэлгийн барилгууд багтаж байна. Цаашилбал, 2012-2016 онд эхлээд дуусаагүй байгаа 13 төсөл байна.

¹ Үндэсний аудитын газар (2018 он). Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.

² Засгийн газар (2020 оны 10 дугаар сар). Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга (<http://forum.parliament.mn/projects/10946>)



Д.ОЮУНБАДАМ (PhD), Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер


ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн хүрээнд төсвийн ил тод, хариуцлагатай байдлын асуудлаар ажилладаг. Тэрээр улс, орон нутгийн төсвийн нээлттэй байдал, төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээрх төслүүдийг удирдаж байв. Мөн эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар олон улсын сэтгүүлүүдэд хэд хэдэн нийтлэл хэвлүүлсэн ([researchgate.net/profile/Oyunbadam_Davaakhuu](https://www.researchgate.net/profile/Oyunbadam_Davaakhuu)). Д.Оюунбадам нь бакалаврын зэргээ Хүмүүнлэгийн ухааны сургуульд, магистрын зэргээ Япон Улсын Waseda-гийн их сургуульд, докторын зэргээ Австрали Улсын Charles Sturt-ийн их сургуульд тус тус хамгаалсан.

Төсвийн тухай хуулийн 29.4: “Хөрөнгө оруулалтын төсөвт ... зураг, төсвөө батлуулсан ... төсөл, арга хэмжээг тусгах” заалтын хэрэгжилт

Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт удаашрахад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу батлагдсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг Засгийн газраас төсөвт тусгаж, түүнийг нь Улсын Их Хурал (УИХ)-аас баталж буй явдал юм. Энэ байдлыг Үндэсний аудитын газраас төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл болон дуусаагүй орхигдсон барилга, байгууламжуудад хийсэн удаа дараагийн аудитаар хөндөж, зөвлөмж өгсөн боловч нөхцөл байдал өнөөг хүртэл давтагдсаар байна. Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасны дагуу шинээр эхлэх барилга байгууламжийг төсөвт суулгах үед зохих үнэлгээ болон зураг, төсөв нь хийгдсэн байх ёстой билээ. Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын аудитын тайланд “2019 онд шинээр эхлүүлэхээр баталсан зураг, төсөв шаардлагатай 638 төсөл, арга хэмжээний 84.3 хувь нь хуулийн шаардлага хангаагүй. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 538 төсөл, арга хэмжээг тусгаснаас үүдэн эдгээр төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж дүгнэжээ.³

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.38 их наяд төгрөгийн 1031 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Эдгээрийн 389 нь 2021 онд шинээр эхлэхээр төлөвлөгдөж нийт 368 тэрбум төгрөг улсын төсөвт тусгагдсан байна. Шинээр эхлүүлэх эдгээр хөрөнгө оруулалтын төслүүдээс мөн л 55 нь зураг, төсөвгүй байгаа талаар Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргажээ.⁴ Зураг, төсөв нь магадлалаар баталгаажуулалгүй эдгээр 55 төслийн нийт төсөвт өртөг 207.8 тэрбум төгрөг, үүнээс 61.5 тэрбум төгрөгийг 2021 онд олгохоор төсөвлөжээ. Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөгтэй (26 тэрбум төгрөг) нь “Дундговь аймгийн төвийн дулааны станцын 2 дугаар хэлхээний 21 км гадна халаалт, хэрэглээний халуун усны шугам сүлжээний угсралтын ажил” юм. Төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Барилга, хот байгуулалтын сайдын багцад зураг, төсөвгүй төсөл 20 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд салбарын яам нь зураг, төсвөө магадлан баталгаажуулалгүйгээр төслүүдийг төсөвт тусгаж, төсөвлөлтийн шаардлагыг хангахад хариуцлагагүй хандаж байгааг харуулж байна (График 1). Эдгээр 20 төслийн төсөвт өртгийг 56.4 тэрбум төгрөг гэж тооцож, 2021 онд 19 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тусгажээ.

График 1. 2021 оны улсын төсвийн төсөл: Зураг, төсөвгүй төслийн тоо (төсвийн ерөнхийлөн захирагчаар)



Эх сурвалж: Үндэсний аудитын газар (2020 оны 10-р сар). Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд өгөх дүгнэлт.

³ Үндэсний аудитын газар (2020 он). Монгол Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит тайлан.

⁴ Үндэсний аудитын газар (2020 оны 10-р сар). Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд өгөх дүгнэлт.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 2.1.4-т “ТЭЗҮ, зураг төсөв” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг (эскиз), ТЭЗҮ, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл ... инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдэл” хэмээн тодорхойлжээ. Нэгэнт энд дурдсан зураг, төсөв нь магадлалаар баталгаажаагүй төслүүдийг төсөвт тусгах нь тухайн төслийн өртгийг тойм дүнгээр оруулсан гэж ойлгохоор байгаа юм. Үндэсний аудитын газраас 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитаар “Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөв нь батлагдаагүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тойм дүнгээр баталснаас худалдан авах ажиллагаа хийгдэж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсаны дараа магадлалаар баталгаажсан төсөв гэрээний дүнгээс бага байгаа нь төсвийн үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлжээ” хэмээн дүгнэж байжээ. 2021 оны төсөвт 10 Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн

журамд нийцэхгүй төслүүдийг Сангийн яаманд ирүүлжээ. Харин төсвийн хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй Сангийн яам эдгээр төслийг төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн барьсан байна.

Цаашилбал зураг, төсөв нь магадлалаар баталгаажаагүй хөрөнгө оруулалтын төслүүдийг УИХ-аас төсвийн төсөл хэлэлцэх явцад нэмж батлуулдаг байдлыг мөн анхаарах нь зүйтэй. Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд багтаагүй олон төслийг УИХ-аар төсөв хэлэлцэх үед нэмж баталдаг ажээ. Нээлттэй Нийгэм Форумгаас УИХ-аар 2019 оны 11 дүгээр сард баталсан 2020 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын төслүүдийг Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөлтэй харьцуулан судалж үзэхэд, УИХ-аар төсөв хэлэлцэх үедээ хөрөнгө оруулалтын 248 төсөл, арга хэмжээг аймгуудад, 101 төсөл, арга хэмжээг нийслэлд шинээр нэмж баталсан байгаа нь харагдсан⁵. Эдгээр нэмсэн төслүүд хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангаж буй эсэх нь ил болоогүй юм. Хэрэв зайлшгүй нэмэх шаардлагатай төслийг УИХ-аар төсөв хэлэлцэх үед нэмэх тохиолдол гарвал зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангаж буй төслийг тусгах нь зүйтэй.

Төсвийн тухай хуулийн 29.3.5: “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” заалтын хэрэгжилт

Төсвийн хөрөнгө оруулалттай зарим төслийн хэрэгжилт удааширч он дамжих, зарим тохиолдолд дуусгалгүй орхиход нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл нь төслийн санхүүжилтийг хэт бага хэмжээгээр олон жилийн туршид цулуулан төсөвт тусгаж буй явдал юм. Ялангуяа шинэ төслүүдийн эхний санхүүжилтийг хэт бага төлөвлөж, эхний жилд нь барилгын шав тавихаас

хэтрэхгүй ажил гүйцэтгэх нь цөөнгүй байна. Мөн он дамжин хийгдэж буй төслүүдийн төлөвлөсөн санхүүжилтийн хэмжээг УИХ-аас бууруулж батлах явдал сүүлийн жилүүдэд ажиглагдаж ирлээ. Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх

⁵ Нээлттэй Нийгэм Форум (2020 он). “2020 оны төсвийн төсөлд тусгаагүй боловч УИХ-аас нэмж баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгаа: Аймгууд” (http://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=499&obj_id=5742); “2020 оны төсвийн төсөлд тусгаагүй боловч УИХ-аас нэмж баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгаа: Нийслэл” (http://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=499&obj_id=5741)

хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” шаардлага туссан байдаг. Энэ заалт нь төслийн санхүүжилтийг бага хэмжээгээр олон хувааж олгосноос үүдэн төсөл он дамжиж удаашрах, улмаар хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, дуусгалгүй орхих эрсдэлүүдээс сэргийлэх зорилго агуулсан байтал энэхүү заалтын хэрэгжилт хангагдахгүй явсаар өдийг хүрлээ.

Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд эхэлж, 2-3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын төслүүдийн дийлэнхэд эхний санхүүжилтийн хэмжээ нь хуулийн энэхүү шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, 2022 онд дуусах төслүүдийн хувьд хуулийн дагуу эхний жилд төсөвт өртгийн 50 болон түүнээс илүү хувийн санхүүжилтийг олгохоор төсөвт тусгах нь зүйд нийцнэ. Харин бодит байдал дээр 2022 онд дуусах хуваарьтай 195 төслийн 152-ынх нь эхний санхүүжилт төсөвт өртгийнх нь 48 болон түүнээс доош хувийг эзэлж байна. Эдгээрээс 12 төслийн эхний санхүүжилт 10 болон түүнээс доош хувьтай байгаа юм (хавсралт 2-ыг харна уу). Тухайлбал, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 13 дугаар

хороон дахь 84 дүгээр сургуулийн өргөтгөлийн эхний санхүүжилт төсөвт өртгийнхөө зөвхөн 1 хувьтай, мөн хороон дахь 100 ортой цэцэрлэгийн барилгын эхний санхүүжилт нь төсөвт өртгийнхөө 3 хувьтай тэнцэж байна.

Ирэх онд шинээр эхэлж 2023 онд дуусах төслүүдийн хувьд 3 жилийн хугацаанд хэрэгжих тул хуулийн дагуу эхний жилд төслийн төсөвт өртгийн 33 буюу түүнээс илүү хувийн санхүүжилтийг тусгах шаардлагатай. Харин 2023 онд дуусах хуваарьтай 14 төслийн 71 хувь буюу 10-ынх нь эхний санхүүжилт төсөвт өртгийн 31 буюу түүнээс доош хувийг эзэлж байна. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт баригдах Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын төсөвт өртөг 2.2 тэрбум байгаагаас эхний санхүүжилтэд 50 сая төгрөг буюу төсөвт өртгийн зөвхөн 2 хувьтай тэнцэх, мөн Сүхбаатар дүүрэгт байршилтай Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилгын төсөвт өртөг 15 тэрбум төгрөг байхаас эхний санхүүжилтэд 1 тэрбум төгрөг буюу төсөвт өртгийн зөвхөн 7 хувьтай тэнцэх санхүүжилтийг төлөвлөжээ.

Төсвийн тухай хуулийн 33.2.6: “Төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ... байршил... -ыг тусгаж, батлах” заалтын хэрэгжилт

Төсвийн тухай хуулийн 33.2.6-д “Төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар (нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн) тусгаж, батална” гэсэн байдаг. Харин 2021 онд шинээр эхлүүлэх зарим төслийн байршлыг нарийвчлан тусгаагүй. Хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад багтсан ихэнх төслийн хувьд хэрэгжих байршлыг аль сум, дүүргийн аль баг, хороогоор нарийвчлан тусгасан атал зарим төслийн хувьд тодорхойгүй байна. Тухайлбал, төслийн байршлыг “улсын хэмжээнд”, “Улаанбаатарт” гэж ерөнхийлөн тусгажээ.

Эдгээрээс дурдвал, Цэргийн албан хаагч болон тусгай чиг үүргийн албан хаагчдын хүүхдийн 150 ортой цэцэрлэгийн барилгын хэрэгжих байршлыг “улсын хэмжээнд”, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн 320 суудалтай сургуулийн барилгын хэрэгжих байршлыг “Улаанбаатар” гэжээ. Мөн “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт” болон “Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт” төслүүдийг тус тус “улсын хэмжээнд” гэж тусгажээ. Тэрчлэн “Сумын төвийн тохижилт” төсөлд Өвөрхангай аймагт 500 сая төгрөг төсөвлөхдөө аль суманд хэрэгжихийг тусгаагүй байна (хавсралт 3-ыг харна уу).

Төсвийн тухай хуулийн 33.2.6: “Төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ... хүчин чадал...-ыг тусгаж, батлах” заалтын хэрэгжилт

2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад хүчин чадал нь тодорхойгүй барилга, байгууламж эхлүүлэхээр оруулжээ. Тухайлбал, 2 жилд баригдаж дуусах барилга, байгууламжууд болох 10 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Дижитал-Эрдэнэт" төсөл Орхон аймагт, 4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Хэнтий аймгийн Галшар сумын "Шинэ сум" төсөл, Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт сумдад тус бүр нь 5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрүүд, Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хэрэгжих “Жишиг гудамж” төсөл зэргийг дурдаж болохоор байна (хавсралт 4-ийг харна уу). Эдгээр төслүүд нь барилга, байгууламж

гэсэн ангилалд багтаж байгаа тул Барилгын тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу хэдэн хүний багтаамжтай ямар барилга, эсхүл барилгын талбайн хэмжээ зэргийг тусгах шаардлагатай юм. Тэрчлэн, 64 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт” төсөл нь барилга, байгууламж гэсэн ангилалд багтаж байгаа боловч мөн барилгуудын хүчин чадал (хэдэн хүний багтаамжтай барилга, хэдэн км зам, гүүр гэх мэт)-ыг тусгаагүй байна. Иймд холбогдох төслүүдийн хүчин чадлын мэдээллийг төсөвт мөн тусгаж, төсвийн мэдээллийн иж бүрэн байдлыг хангах хэрэгтэй юм.

Төсвийн тухай хуулийн 29.3.4: “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр жилийн төсвийн төсөлд тусгах” заалтын хэрэгжилт

2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад Сангийн сайдын багцад гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалтыг төсөл тус бүрээр бус бөөн дүнгээр 64 тэрбум төгрөг гэж тусгажээ. Ихээхэн хэмжээний хөрөнгө төсөвлөсөн энэхүү хөрөнгө оруулалтыг төсөл тус бүрээр тодорхой тусгах шаардлагатай.

Хөрөнгө оруулалтын шинэ төслүүдийн танилцуулга

Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд шинээр эхлэх төслүүдийн төлөвлөлтөд дээр дурдсанаас гадна анхаарал татах асуудлууд байна. Хөрөнгө оруулалтын жагсаалтад барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн нэрээр бус “төсөл” нэрээр орсон ихээхэн хэмжээний төсөвт өртөг бүхий

зардлуудын талаарх танилцуулга мэдээлэл уг жагсаалтад ч, хуулийн төслийн танилцуулгад ч тусгагдалгүй орхигджээ. Тухайлбал, "Их соёл-Эх үндэс" төсөл, хөтөлбөрийг Дундговь аймагт хэрэгжүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад 300 сая төгрөг, Соёлын сайдын багцад 200 сая төгрөгийг зэрэг тусгасан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад "Шинэ хөдөө" гэх төслийг 6 аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эдгээр төсөл нь 200 саяас 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байх аж. Мөн 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Эрүүл хүнс-Малчны хотноос" хөтөлбөрийн хүрээнд Архангай аймагт тоног төхөөрөмж худалдан авахаар тусгажээ (хавсралт 5-ыг харна уу).

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Төсвийн тухай хууль, журамд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд тавигдах шаардлагыг тодорхой тусгаж өгсөн байдаг ч хэрэгжилт нь хангагдахгүй байна. Төсвийн тухай хуулийн 29.4 дүгээр заалтыг хангаагүй буюу зураг, төсөв нь магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээг Засгийн газраас төсөвт тусгаж, түүнийг нь УИХ-аас баталж ирлээ. Үүнээс гадна Хуулийн 29.3.5 дугаар заалтыг зөрчин шинээр эхлэх төслүүдийн эхний санхүүжилтийг хэт бага төлөвлөж, батлах байдал үргэлжилсээр байна. Мөн зарим шилжих төслийн санхүүжилтийг УИХ-аас бууруулан батлах явдал давтагдаж ирлээ. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалттай зарим төслийн хэрэгжилт удааширч он дамжих, улмаар дуусгалгүй орхигдож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах гол хүчин зүйлс болж байна. Үүнтэй зэрэгцэн 2021 онд шинээр эхлүүлэх улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын зарим төсөл мөн төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна. Иймээс төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, журмын дагуу хийж гүйцэтгэх, хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн маягтыг сайжруулах чиглэлээр дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг зохицуулж буй доорх заалтуудад нийцсэн төслүүдийг УИХ-аас төсөвт суулгаж батлах шаардлагатай. Үүнд:
 - 29.4: Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгах;
 - 29.3.5: Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах;
- 33.2.6: Төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн)-ыг хавсралтаар тусгаж, батлах;
- 29.3.4: Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр жилийн төсвийн төсөлд тусгах.
- УИХ-аар төсөв хэлэлцэх явцад хөрөнгө оруулалтын төсөл нэмэх тохиолдолд уг төсөл нь төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангаж буй эсэх талаар Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргуулдаг болох, зөвхөн төлөвлөлтийн шаардлага бүрэн хангаж буй, хойшлуулшгүй төслийг л нэмж баталдаг байх.
- Зураг, төсөвгүй хөрөнгө оруулалтын төслүүдийг улсын төсөвт тусгаж, батлах явдал давтагдсаар байгаа тул жил бүрийн Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт дахь “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” маягтад “Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх” шаардлагыг хангаж буй эсэх мэдээллийг төсөл тус бүрээр тусгах байдлаар өөрчлөлт оруулах.
- Засгийн газраас хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн мэдээллийн агуулгыг сайжруулж, жил бүрийн төсвийн төслийн танилцуулгад шинэ төслүүдийн мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар тусгаж өгөх хэрэгтэй. Ялангуяа, барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн төрлийг дурдалгүй “төсөл” гэсэн ерөнхий нэрээр төлөвлөгдсөн томоохон дүнтэй зардлуудын дэлгэрэнгүй танилцуулгыг багтаах.
- Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг УИХ, Засгийн газар үйл ажиллагаандаа тусгаж байх.
- Төсвийн тухай хууль зөрчсөн албан тушаалтанд Хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэдэг байх.

Хавсралт 1. 2021 оны улсын төсвийн төсөлд туссан он дамжсан барилгууд (2010-2016 онуудад эхэлсэн)

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1	II.1.1.1 Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудалтай (УБ, БЗД)	2010	11,015	50
2	II.1.1.2 Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудалтай (УБ, СБД)	2010	9,937	1,500
3	II.1.1.4 Дүүргийн спорт цогцолбор, 700 суудалтай (УБ, Налайх дүүрэг)	2010	13,498	50
4	II.1.1.5 Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудалтай (УБ, ХУД)	2010	7,280	50
5	II.1.1.14 Спорт цогцолбор, 2200 суудал (Дархан-Уул, Дархан сум)	2010	27,116	2,000
6	IV.1.1.1 Аймгийн Засаг даргын тамгын газрын барилга (Дорнод, Чойбалсан)	2011	7,500	50
7	XI.1.58 Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл сорил шинжилгээний төв лабораторийн барилга (УБ, СХД)	2011	4,184	50
8	XIII.1.1.1 "Төв халх" дуулалт жүжгийн театр (Дундговь, Сайнцагаан сум)	2011	10,544	1,710
9	XIII.1.1.45 Ханхэнтий чуулгын барилга (Хэнтий, Хэрлэн сум)	2011	11,459	606
10	XIII.1.1.46 Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал (Завхан, Улиастай сум)	2011	13,492	2,032
11	XVIII.1.18 Төрөх эмнэлэг, 50 ортой (Дорноговь, Сайншанд сум)	2011	8,275	676
12	XIII.1.1.4 Аймгийн хөгжимт драмын театрын барилга (Архангай, Эрдэнэбулган сум)	2012	13,492	1,000
13	XIII.1.1.1 Соёлын өвийн төвийн барилга (УБ, ХУД)	2012	8,000	316
14	X.2.1.3 Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр (Орхон, Баян-Өндөр сум)	2013	4,910	2,615
15	XVIII.1.10 Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ортой (Дорноговь, Замын-Үүд сум)	2013	8,058	50
16	XXI.1.1 Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр (УБ, ХУД)	2013	18,931	8,000
17	II.1.1.3 Дүүргийн спорт цогцолбор, 700 суудалтай (УБ, БГД)	2014	9,005	1,779
18	X.1.1.3 Усан спорт цогцолбор (УБ, СХД, Найрамдал зуслан)	2014	9,600	1,378
19	XI.1.35 Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил (1-р хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км) (УБ, СХД)	2014	24,949	5,000
20	XII.1.1.164 Цэцэрлэгийн барилга, 150 ор (Орхон, Баян-Өндөр сум)	2014	1,651	50
21	XIV.1.1.38 Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын дуусгал	2015	6,091	6,091
22	XVII.1.2 12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø400 мм голчтой шугамыг 2 Ø500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт (УБ)	2015	6,527	468
23	XI.1.56 Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх 20000 м³ байгууламжийн гадна дулааны шугамын нэмэлт ажил (УБ, ХУД)	2016	1,260	50
24	XIV.1.1.42 Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга (60 км)	2016	18,174	1,255
	НИЙТ		254,948	36,826

Хавсралт 2. 2021 оны улсын төсвийн төсөл: Эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 10 буюу түүнээс доош хувийг эзэлж буй шинээр эхлэх төслүүд

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг (сая төг)	2021 онд санхүүжих дүн (сая төг)	нийт төсөвт эзлэх хувь
2022 онд дуусах төслүүд					
XII.1.1.226	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудалтай (УБ, БЗД, 13-р хороо, 84-р сургууль)	2022	3,800	50	1%
XII.1.1.238	Цэцэрлэгийн барилга, 100 ортой (УБ, БЗД, 13-р хороо)	2022	1,500	50	3%
XII.1.1.220	Сургуулийн барилга, 440 суудалтай (Өвөрхангай, Бат-Өлзий сум)	2022	5,000	200	4%
XIV.1.1.64	Сумын төвийн авто зам, 7 км (Архангай, Өндөр-Улаан сум)	2022	6,300	300	5%
IX.2.3.1	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт (Улсын хэмжээнд)	2022	17,325	1,000	6%
II.1.1.25	Спортын ордны барилга (Архангай, Эрдэнэбулган сум)	2022	7,900	500	6%

XI.1.81	Сумын төвийн тохижилт (Увс, Түргэн сум)	2022	1,400	100	7%
XII.1.1.212	Дотуур байрын барилга, 200 ортой (Хөвсгөл, Мөрөн сум, 14-р баг)	2022	2,400	200	8%
V.1.14	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн (Хөвсгөл, Мөрөн сум)	2022	2,000	200	10%
XII.1.1.207	Багшийн хөгжлийн төвийн барилга (Ховд, Жаргалант сум)	2022	2,000	200	10%
XIV.2.1.16	Хануй голын төмөр бетон гүүр (Архангай, Хайрхан сум)	2022	3,500	350	10%
XII.1.1.217	Сургуулийн барилга, 320 суудалтай (Говь-Алтай, Цээл сум)	2022	3,939	400	10%
2023 онд дуусах төслүүд					
XVIII.1.39	Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга (УБ, БЗД)	2023	2,200	50	2%
XII.1.1.209	Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилга (УБ, СБД)	2023	15,000	1,000	7%

Хавсралт 3. 2021 оны улсын төсвийн төсөл: Хэрэгжих байршлыг тодорхой заагаагүй төслүүд (сая төг)

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
VI.1.4	Цэргийн албан хаагч болон тусгай чиг үүргийн албан хаагчдын хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор (Улсын хэмжээнд)	2021	1,500	1,500
VIII.2.1.1	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт (Улсын хэмжээнд)	2021	64,000	64,000
IX.2.3.1	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт (Улсын хэмжээнд)	2022	17,325	1,000
XII.1.1.232	Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуулийн барилга, 320 суудал (Улаанбаатар)	2022	4,000	2,000
XI.1.80	Сумын төвийн тохижилт (Өвөрхангай)	2021	500	500

Хавсралт 4. 2021 оны улсын төсвийн төсөл: Хүчин чадал тодорхойгүй барилга, байгууламжууд (сая төгрөг)

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
IV.3.1.2	"Дижитал-Эрдэнэт" төсөл (Орхон)	2022	10,000	2,000
VIII.2.1.1	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт (Улсын хэмжээнд)	2021	64,000	64,000
XI.1.104	"Шинэ сум" төсөл (Хэнтий, Галшар сум)	2022	4,000	1,600
XI.1.107	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр (Баянхонгор, Галуут сум)	2022	5,000	1,500
XI.1.108	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр (Баянхонгор, Эрдэнэцогт сум)	2022	5,000	1,500
XI.1.111	Жишиг гудамж (УБ, БГД, 9, 10, 11, 21, 22, 23-р хороо)	2022	2,500	700

Хавсралт 5. 2021 оны улсын төсвийн төсөл: Хийгдэх ажлын танилцуулга шаардлагатай төслүүд (сая төгрөг)

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
XII.2.3.1	"Их соёл-Эх үндэс" төсөл, хөтөлбөр (Дундговь)	2021	300	300
XIII.1.3.1	"Их соёл-Эх үндэс" төсөл, хөтөлбөр (Дундговь)	2021	200	200
XVI.3.2	"Шинэ хөдөө" төсөл (Булган)	2021	1,000	1,000
XVI.3.3	"Шинэ хөдөө" төсөл (Говьсүмбэр)	2021	200	200
XVI.3.4	"Шинэ хөдөө" төсөл (Дундговь)	2021	300	300
XVI.3.5	"Шинэ хөдөө" төсөл (Увс)	2023	4,500	650
XVI.3.6	"Шинэ хөдөө" төсөл (Ховд)	2021	280	280
XVI.3.7	"Шинэ хөдөө" төсөл (Хөвсгөл)	2021	500	500
XVI.3.8	"Эрүүл хүнс - Малчны хотноос" хөтөлбөр (Архангай)	2021	1,000	1,000

Эх сурвалж: Засгийн газар (2020 оны 10 дугаар сар). Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга (<http://forum.parliament.mn/projects/10946>)